МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 27 өдөр Дугаар А/397 Мандалговь

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын
эсрэг нэмэлт дархлаажуулалтын
ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 зүйлийн 29.1.5."в", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Зорилтот насны хүн амыг коронавируст (КОВИД-19) халдварын эсрэг дархлаажуулалтын бүрэн тунд хамруулах, 2 дахь тунгийн вакцин хийлгээд 3 сар түүнээс дээш хугацаа болсон иргэдийг дархлаа сэргээх нэмэлт 3 дахь тунд бүрэн хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг сумдын Онцгой комиссын дарга нар, байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

2.Коронавируст (КОВИД-19) халдварын эсрэг дархлаажуулалтад шаардлагатай вакцин, дагалдах хэрэгслийн нөөц бүрдүүлж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс)-т үүрэг болгосугай.

3. Коронавируст (КОВИД-19) халдварын эсрэг дархлаажуулалтын үр нөлөө, ач холбогдлыг нийгэмд сурталчлан таниулах сургалт, сурталчилгааг өргөн хүрээнд зохион байгуулж ажиллахыг Сумдын онцгой комисс, төрийн байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

481210563